ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ
ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ /Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам/

2010 оны 07 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 388 Улаанбаатар хот

Гаалийн тухай хуулийн 67.3 дахь хэсэг, 271.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам” –ыг 1 дүгээр, “Гаалийн зуучлалын үйл ажиллагаа эрхлэх нутаг дэвсгэрийн багцын хуваарилалт”-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлалсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг зохион байгуулж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дэд дарга /Д.Оюунчимэг/, Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн хэлтэс /Д.Баасан/-т даалгасугай.

3. Энэ тушаалыг 2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн 674 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Д.ЦЭВЭЭНЖАВ

Улсын бүртгэлд 2010 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 3185 дугаарт бүртгэсэн.

ГЕГ-ын даргын 2014 оны 3 сарын 21-ний өдрийн А/53 дугаар тушаалаар орсон нэмэлтийг тусгав.